

БАТЛАВ.  
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
НАЛАЙХ ТҮГЭЭХ ТӨВИЙН ДАРГА  
..... Н.МАНАЛЖАВ

2017 оны 12 сарын 21 өдөр

### ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ.

Дугаар 155/2017.

Налайх дүүрэг

#### Нэг. Ерөнхий мэдээлэл:

|     |                                  |  |
|-----|----------------------------------|--|
| 1.1 | Хүсэлтийн дугаар                 | 17074  |
| 1.2 | Хэрэглэгчийн нэр, регистр        | НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  |
| 1.3 | Хэрэглэгчийн байршил:            | Налайх дүүргийн 1,3,4,7 дугаар хорооны гэр хороололд   |
| 1.4 | Ажил үйлчилгээний зориулалт:     | Гудамжны гэрэлтүүлэг   |
| 1.5 | Техникийн нөхцөл олгох үндэслэл: | 1) Налайх дүүргийн ЗДТГ-ын 2017.12.06-ны өдрийн 05/2448 тоот албан бичиг<br>2) Шинэ холболтын хүсэлт |
| 1.6 | Тооцооны бүрэн чадал:            | 15 кВА (тоогоор) /Арван тав/ (үсгээр)  |

#### Хоёр. Холболтын цэг:

|     |   |
|-----|---|
| 2.1 | 1 дүгээр хорооны Баянзүрх, Энгэршанд, Өндөрнастан гудамжны гэрэлтүүлгийг АТП-7007, АТП-7081, ХТП-7024-өөс, 3 дугаар хорооны Дэнж гудамжны гэрэлтүүлгийг АТП-7063-аас, 4 дүгээр хорооны Их ам, Алтай, Өлгий, Туул, Нисэх гудамжны гэрэлтүүлгийг АТП-7480, АТП-7070, АТП-7507, АТП-7012-оос, 7 дугаар хорооны Бадрал гудамжны гэрэлтүүлгийг ХТП-7023-аас тус тус кабель шугам татаж тэжээх. |
|-----|---|

#### Гурав. Тоолуур:

|     |  |
|-----|--|
| 3.1 | Өөрийн байранд МУ-ын стандартын шаардлага хангасан гурван фазын электрон тоолуур хэрэглээний шитнээс тусад нь цоож бүхий тусгай хайрцагт байрлуулж, түлхүүрийг НАЛАЙХ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ-д хүлээлгэн өгөх. |
|-----|--|

#### Дөрөв. Тусгай заалтууд:

|     |  |
|-----|--|
| 4.1 | 0.4 кВ-ын агаарын болон кабель шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, Барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газраар батлуулж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус түгээх төвөөр хянуулах.  |
| 4.2 | Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг <a href="http://www.tog.mn">www.tog.mn</a> хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх. |

- |     |  |
|-----|--|
| 4.3 | Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах   |
| 4.4 | Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж, протокол авсан байх. |
| 4.5 | Угсралтын ажлын явцад тус түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх   |
| 4.6 | Цахилгаан эрчим хүчний тооцоог НАЛАЙХ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ-тэй хийх.   |

**Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

- |     |   |
|-----|---|
| 5.1 | Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай хууль"-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.  |
| 5.2 | Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. |
| 5.3 | "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8 д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийж хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.   |
| 5.4 | "Эрчим хүчний тухай хууль"-ийн болон "Цахилгаан эрчим хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг дагаж мөрдөх.  |

**Зургаа. Бусад**

- |     |   |
|-----|---|
| 6.1 | Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж, гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна. |
|-----|---|

КОМИССЫН ГИШҮҮД:



П.ТҮМЭНБАЯР

Б.АЛТАНШАГАЙ